



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/147

Чингис хот

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "г", Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.4, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 2 дугаар багийн иргэн Б.Дуламбатын ирүүлсэн хүсэлтийн дагуу хүү М.Мөнгөншагайгийн Пара олимпын тэмцээнд оролцох зардалд зориулан буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардагдах 500000 /таван зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын тэтгэмж урамшууллын зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА